



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 1022

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.2, 4.5.3, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Бүрэгтий багийн Гурван модны худаг засвар, Цагаан овооны худаг засвар, Зүүн сөдтийн дунд халзаны худаг засвар, Зөрүүлэг багийн Урд-Агуйтын амны худаг засварын ажлыг иргэн Х.Анхбаяртай шууд гэрээ байгуулах аргаар гүйцэтгүүлсүгэй.


2. иргэн Х.Анхбаяртай гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Зардалд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн Малын тоо толгойн албан татварын бусад хөрөнгө зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga

627301505